



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/547

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1./а/, 29.2 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 13.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит 3 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 65 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Ач санах” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Ахмадыг хөгжлийн төвийн гаднах тохижилтонд 1800000 төгрөгийн, Монголын Ахмадын баярын өдрийг тохиолдуулан Соёмбо холбооноос зохион байгуулж буй спортын үйл ажиллагаанд 900000 төгрөгийн, Эрдэнэтийн овооны анхдагч илгээлтийн эздийн холбооноос зохион байгуулж буй Эрдэнэзуу-Улаан цутгалан-Төвхөн хийдийн чиглэлд аялал, туршлага судлах үйл ажиллагаанд 2500000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 1800000 /Нэг сая найман зуун мянга/ төгрөгийг “Багуудад үйл ажиллагаа явуулж байгаа ахмадын төвүүдийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулж, тогтмолжуулах арга хэмжээний зардал”-аас, 900000 /Есөн зуун мянга/ төгрөгийг “Ахмад настнуудын хөдөлмөр бүтээлийг алдаршуулах төрөл бүрийн олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулах зардал”-аас, 2500000 /Хоёр сая таван зуун мянган/ төгрөгийг “Ахмадуудад үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын дунд ажил мэргэжлийн туршлага солилцох үйл ажиллагаа зохион байгуулах, ТББ-уудыг чадавхижуулах, уялдаа холбоог хангах, хяналт тавих, хүүхэд, дунд үе, ахмад настны гурван үеийн чуулга уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж хэвшил болгох зардал”-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



А.ТҮВШИНЖАРГАЛ